

“ҮР ДҮНД СУУРИЛСАН БОЛОВСРОЛ - CDIO”

эрдэм шинжилгээний хурлын удирдамж

“Дээд боловсролын шинэчлэлийн төсөл” болон уг төслийн хүрээнд хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэгч их дээд сургуулиуд хамтран зохион байгуулж буй “Үр дүнд суурилсан боловсрол” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2018 оны 12-р сарын 07-ны өдрийн 14:00 цагаас ШУТИС-ийн Шинжлэх ухаан технологийн төв номын сангийн 604 тоот өрөөнд зохион байгуулна.

Зохион байгуулагч:

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУСЯ)
- Дээд боловсролын шинэчлэлийн төсөл (ДБШТ)
- Шинжлэх ухаан технологийн их сургууль (ШУТИС)
- Монгол Улсын их сургууль (МУИС)
- Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС)
- Соёл урлагийн их сургууль (СУИС)
- Үндэсний батлан хамгаалахын их сургууль (ҮБХИС)
- Монгол Улсын боловсролын их сургууль (МУБИС)
- Техник технологийн дээд сургууль (ТТДС)

Зорилго:

Дээд боловсролын салбарт үр дүнд суурилсан боловсролын арга зүйг мэргэжлийн чиглэл бүрд тохируулан нэвтрүүлж буй туршлагаа солилцох, инженерийн боловсролд CDIO стандартыг нэвтрүүлж буй үр дүнг тайлагнах, идэвхитэй сургалтын арга зүйг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа багш, судлаач, эрдэмтэд судалгааны ажлаа танилцуулах, их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, санал солилцох таатай нөхцөл бүрдүүлэхэд оршиж байна.

Хуралдааны салбар, чиглэлүүд:

1. CDIO арга зүйг хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөр
2. CDIO арга зүйг нэвтрүүлж буй туршлагауд
3. Харилцан уялдаатай хичээлүүд бүхий нийлмэл сургалтын төлөвлөгөө боловсруулах арга зүй, туршилт
4. CDIO арга зүйг нэвтрүүлэхэд тулгарч буй асуудлууд, шийдвэрлэх арга зам
5. Идэвхитэй сургалтын арга зүй, хэлбэрүүд
6. Хөтөлбөрт үнэлгээг хийх арга зүй, үнэлгээний хэлбэр
7. CDIO болон хувь хүний ур чадвар

Хугацаа:

- Өгүүллийг хянан хэлэлцэх 12 сарын 1-ний өдрийн 18 цагаас өмнө

- Илтгэл хүлээн авах — 12 сарын 3-ны өдрийн 18 цагаас өмнө
- Илтгэлийг хянан хэлэлцэх—12 сарын 1-ний өдрөөс 12 сарын 06-ны өдрүүд
- Зохиогчдод мэдэгдэх—12 сарын 5-ны өдөр
- Ханан илтгэлээ байрлуулах—12 сарын 06-ны өдрийн 18 цаг

Өгүүлэл:

- Өгүүллийг монгол, англи, орос хэлээр ирүүлж болно.
- Өгүүллийг 2018 оны 12-р сарын 1-ний өдрийн 18 цагаас өмнө bolormaa@seas.num.edu.mn майл хаягаар ирүүлнэ үү. Хянагдсан өгүүлэл “Үр дүнд суурилсан боловсрол-3” бүтээлийн эмхтгэлд хэвлэгдэнэ.
- Өгүүллийг https://www.ieee.org/publications_standards/publications/authors/author_templates.html хаягаар орон [Template and Instructions on How to Create Your Paper](#) (DOC, 506 KB) Файлын загвараар бэлтгэнэ.

Илтгэл:

- Илтгэх хугацаа 15 минут байна.
- Илтгэлийг 2018 оны 12-р сарын 3-ны өдрийн 18 цагаас өмнө bolormaa@seas.num.edu.mn майл хаягаар ирүүлнэ үү.
- Илтгэлийн материал “Үр дүнд суурилсан боловсрол-3” бүтээлийн эмхтгэлд хэвлэгдэнэ.
- Илтгэлийг монгол болон англи хэлээр илтгэж болно.
- Илтгэлийг .ppt өргөтгөлтэй файлаар 12 сарын 7-ны өдрийн өглөө бүртгэлийн үед зохион байгуулах комиссын бэлтгэсэн компьютерт хуулах тул файлаар авчирна.
- Ханын илтгэлийг А1 эсвэл А0 хэмжээгээр бэлтгэн үзүүлнэ.

Хурлыг зохион байгуулах комисс:

Дарга:	Д. Оюун (ШУТИС)
Гишүүд:	Д.Болормаа (МУИС)
	Д.Ариунболор (ДБШТөсөл)
	Р.Найдандорж (ШУТИС)
	Ц.Баярмаа (ТТДС)
	Д.Түмэнболд (ШУТИС)
	Д.Сэрээтэрдорж (МУБИС)
	Ш.Мандалмаа (СУИС)
	Б.Дарханцэцэг (ҮБХИС)
	Н.Бат-Эрдэнэ (ХААИС)

Е-майл хаяг: oyund@must.edu.mn
bolormaa@seas.num.edu.mn

Харилцах утас: 99055056, 88054542